##### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар**

Баяннуур сумын Засаг дарга нь Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Тус албанаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхтэй холбоотой Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна..

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 93.2 сая төгрөгөөр буюу 6.8 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	501,105.30	373,696.66	(127,408.64)
Авлага	190,555.06	242,981.46	52,426.40
Урьдчилж гарсан зардал	-	-	-
Бараа материал	3,126.11	20,458.99	17,332.88
Нөөцийн бараа	-	-	-
Үндсэн хөрөнгө	674,633.39	825,521.81	150,888.42
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,369,419.85</b>	<b>1,462,658.91</b>	<b>93,239.06</b>
Өр төлбөр	9,844.73	1,317.97	(8,526.76)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,359,575.12	1,461,340.94	101,765.82
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,369,419.85</b>	<b>1,462,658.91</b>	<b>93,239.06</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Судалгаанаас харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, нөөцийн бараа, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данстад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 373.7 сая төгрөг болж, оны эхнээс 127.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>	-	-	-
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>501,105.29</b>	<b>373,696.65</b>	<b>(127,408.64)</b>
<b>Төгрөг</b>	<b>501,105.29</b>	<b>373,696.65</b>	<b>(127,408.64)</b>
Төрийн сангийн харилцах	501,105.29	373,696.65	(127,408.64)
Арилжааны банк дахь харилцах			-
<b>Дүн</b>	<b>501,105.29</b>	<b>373,696.65</b>	<b>(127,408.64)</b>

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь Орон нутгийн ерөнхий орлогын данс, ОНХС, ХХС-гийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсантай холбоотой байна. Орон нутгийн ерөнхий орлогын данс 106.6 сая төгрөгийн, ОНХС-гийн данс 231.4 сая төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн данс 35.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Аудитын илрүүлэлт: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.*

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 238.1 сая төгрөг болж, оны эхнээс 54.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	3,294.50	1,434.56	(1,859.94)
Зээлийн хүүгийн авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	3,430.90	3,430.90	-
Хувь хүмүүсээс авах авлага			-
<b>Зээлийн авлага</b>	<b>183,829.66</b>	<b>238,116.01</b>	<b>54,286.35</b>
Хувь хүмүүст олгосон зээл	183,829.66	238,116.01	54,286.35
<b>Дүн</b>	<b>183,829.66</b>	<b>238,116.01</b>	<b>54,286.35</b>

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Авлагын дансны үлдэгдэл буурсан нь сумын Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 54.3 сая төгрөгөөр өсч, ажиллагчтай холбогдсон авлага 1.8 сая төгрөгөөр буурсан байна. ХХС-гийн эргэн төлөлтөөс 54.3 сая төгрөгийн зээл олгосон байна.

*Аудитын илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангаас 16.8 сая төгрөгийн зээлийн хариуцагч нь нас барсан, Казакстан улс руу нүүсэн гэх мэт шалтгаанаар төлөгдөх найдваргүй болж хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.*

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 20.4 сая төгрөг болж, оны эхнээс 17.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>			
Эм боох материал			
<b>Хангамжийн материал</b>	<b>2,376.11</b>	<b>19,708.99</b>	<b>17,332.88</b>
Бичиг хэргийн материал	210.73	183.73	(27.00)
Аж ахуйн материал	-	18,250.00	18,250.00
Сэлбэг хэрэгсэл	1,073.90	1,073.90	-
Түлш, шатах тослох материал	1,091.48	201.36	(890.13)
<b>Мал амьтад</b>	<b>750.00</b>	<b>750.00</b>	<b>-</b>
<b>Дүн</b>	<b>3,126.11</b>	<b>20,458.99</b>	<b>17,332.88</b>

Эх сурвалж: [Аудит хийсэн санхүүгийн тайлан](#)

Бараа материалын үлдэгдэл буурсан нь сумын ЗДТГ-ын аж ахуй, түлш шатах тослох материалын нэмэгдсэнтэй холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт:** Бараа материал данстай холбоотой зөрчил гараагүй.

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Нөөцийн барааны дансанд өөрчлөлт ороогүй байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 797.9 сая төгрөг болж, оны эхнээс 150.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>647,802.59</b>	<b>797,921.01</b>	<b>150,118.42</b>
Барилга, байгууламж, орон сууц	418,811.13	563,002.92	144,191.80
Авто-тээврийн хэрэгсэл	31,287.46	135,999.67	104,712.22
Машин тоног төхөөрөмж(компьютер)	39,752.85	79,307.50	39,554.64
Тавилга, аж ахуйн эд хогшил	7,422.12	13,492.41	6,070.29
Зам, гүүрийн байгууламж	5,834.50	5,834.50	-
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	-	-
Бусад үндсэн хөрөнгө	144,410.53	-	(144,410.53)
Ном	284.00	284.00	-
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>26,830.80</b>	<b>27,600.80</b>	<b>770.00</b>
Программ хангамж	-	770.00	770.00

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусад биет бус хөрөнгө	26,830.80	26,830.80	-
<b>Дүн</b>	<b>674,633.39</b>	<b>825,521.81</b>	<b>150,888.42</b>

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Үндсэн хөрөнгийн данс өссөн нь ЗДТГ-ын төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгө, аймаг, сумын ОНХС-гийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

*Аудитын илрүүлэлт: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар үндсэн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.*

*Сумын ЗДТГ төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 115.6 сая төгрөгийн хөрөнгийг зардлаар тайлагнаж ирүүлснийг аудитаар залруулсан.*

### 3.5.7 Өр төлбөр

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 1.3 сая төгрөг болж, 8.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Өглөг</b>	<b>1,212.94</b>	<b>1,317.97</b>	<b>105.03</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	1,212.94	1,317.97	105.03
Бараа үйлчилгээний зардлын өглөг			-
<b>Бусад өглөг</b>	<b>8,631.79</b>	<b>-</b>	<b>(8,631.79)</b>
Байгууллагад төлөх өглөг	8,631.79		(8,631.79)
Хувь хүмүүст төлөх өглөг			
<b>Дүн</b>	<b>9,844.73</b>	<b>1,317.97</b>	<b>(8,526.76)</b>

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Өр төлбөр данс оны эхний үлдэгдлийг барагдуулж, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал ажилчидтай холбогдсон өглөгийн 1.3 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

*Аудитын илрүүлэлт: Өглөг данстай холбоотой зөрчил гараагүй.*

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант оны үр дүнгийн хэмжээгээр 101.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	410,304.24	410,304.24	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>776,845.76</b>	<b>878,611.57</b>	<b>101,765.81</b>
Өмнөх үеийн үр дүн	494,802.06	776,845.76	282,043.70
Тайлант үеийн үр дүн	282,043.70	101,765.81	(180,277.89)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	172,425.11	172,425.11	-
<b>Дүн</b>	<b>1,359,575.11</b>	<b>1,461,340.92</b>	<b>101,765.81</b>

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Баяннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан нийтдээ 2,413.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,832.3 сая төгрөгийг урсгал зардалд, 580.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд баталжээ.

Нийт зардлын 1,694.9 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвийн орлогоос, 245.3 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр, 130.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэн, 343.1 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Баяннуур сум нь 2024 онд гүйцэтгэлээр нийтдээ 2,026.1 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс сумын орон нутгийн төсвөөс 1,589.4 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 235.1 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 44.6 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 14.2 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой 62.7 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, оны эцэст орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 52.8 сая төгрөгийг төвлөрүүлж, үндсэн үйл ажиллагааны орлого /Хоршоо хөгжүүлэх сан/ 85.4 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,026.1 сая төгрөг буюу 86 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлого, эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

#### **Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:**

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 44.6 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны “2024 оны төсөвт тодотгол хийх тухай” 2024 оны 262 дугаар тодотголоор 838.4 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 57 дугаар тогтоолоор Баяннуур сумын 2024 орлогын төлөвлөгөөг 585.2 сая төгрөгөөр баталж, сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 76 дугаар тогтоолоор орлогын төлөвлөгөөг анх баталснаас 265.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 850.4 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Гүйцэтгэлээр сумын орон нутгийн төсвийн орлогод нийтдээ 799.5 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө нь 50.9 сая төгрөгөөр буюу 6 хувиар тасарсан байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварын орлогоос ХХОАТ-ын буцаан олголтод 75.0 сая төгрөг олгосон байна.

Хүснэгт №8 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Төлөвлөгөө</u>	<u>Гүйцэтгэл</u>	<u>Өсөлт/+, бууралт /-/ бүрэлд</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
I.Татварын орлого	863.1	787.1	-76.1	91.2
II.Татварын бус орлого	27.2	12.4	-14.8	45.6

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>Нийт дүн</b>	<b>890.3</b>	<b>799.5</b>	<b>-90.8</b>	<b>89.8</b>
-----------------	--------------	--------------	--------------	-------------

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Орон нутгийн орлого тасрахад цалин хөлсний орлого 98.7 сая төгрөгөөр, малын тоо толгойн албан татварын орлого 23.9 сая төгрөгөөр, газрын татварын орлого 4.5 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 7.6 сая төгрөгөөр, хог хаягдлын хураамж 3.0 сая төгрөгөөр, ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр 2.9 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлого 15.4 сая төгрөгөөр тасарч, Үйл ажиллагааны орлогын албан татварын орлого 51.8 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 8.9 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогоос 0.6 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 0.7 сая төгрөгөөр, агнуурын нөөцийн төлбөр орлогоос 1.7 сая төгрөгийн орлого давж оруулсан нь орон нутгийн орлого 90.8 сая төгрөгөөр тасрахад нөлөөлсөн байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 91.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 787.1 сая төгрөгийн татварын орлого оруулж, аймгаас 804.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, орлого төвлөрүүлэлтээс 875.5 сая төгрөг орж нийт 53.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 912.6 сая төгрөгийн төсвийг зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 106.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №9 Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар:

*/мянган төгрөгөөр/*

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХурал	189,740.00	183,941.61	5,798.39
2	Сумын ЗДТГазар	952,214.40	890,146.93	62,067.47
3	Сум хөгжүүлэх сан	130,000.00	123,101.13	6,898.87
4	ОНХСан	580,949.30	320,931.63	260,017.67
1	Ерөнхий боловсролын 1-р сургууль	323,440.00	289,495.85	33,944.15
2	Ерөнхий боловсролын 2-р сургууль	18,828.00	17,731.90	1,096.10
3	Ерөнхий боловсролын 3-р сургууль	24,644.00	19,800.00	4,844.00
4	Хүүхдийн цэцэрлэг	83,760.70	73,704.91	10,055.79
5	Соёлын төв	50,947.90	48,850.90	2,097.00
6	Эрүүл мэндийн төв	58,759.80	58,400.00	359.80
	<b>Нийт дүн</b>	<b>2,413,284.10</b>	<b>2,026,104.86</b>	<b>387,179.24</b>

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Хүснэгтээс үзэхэд сумын ИТХ, ЗДТГ-ын төсвийн гүйцэтгэл төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь төлөвлөлттэй холбоотой, ОНХС-гийн төсвийн гүйцэтгэл он дамжсан төсөл арга хэмжээний дутуу олгосон санхүүжилттэй холбоотой байна..

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 4.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 22.5 сая төгрөгийн нийтдээ 26.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, хангамж, дотоод албан томилолтын зардалд 1.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 22.3 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 0.7 сая төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 01/75 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,978.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 44.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоосон .

Гүйцэтгэх шатны материаллаг байдлыг Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,313.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 49.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд үйл ажиллагаатай хамааралтай 2 шалгуурт алдаа, зөрчил илрээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,642.4 сая төгрөгийн орлогын 42 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1,067.2 сая төгрөгийн зарлагын 63 мөнгөн гүйлгээг шилэн дансанд бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Засаг даргын захирамжаар Хоршоо хөгжүүлэх сангаас 64.0 сая төгрөгийн зээл олгосон, Орон нутгийн хөгжлийн сангаас 139.9 сая төгрөг олгосон шийдвэрийг шилэн дансанд нөхөн байршуулж зөрчлийг арилгах, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ....” заасны дагуу мэдээллийг хугацаанд мэдээлж ажиллах,

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой тодруулга, танилцуулгыг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5-д зааснаар иж бүрэн гарган ирүүлж байх гэсэн 2 зөвлөмж өгөгдсөнийг зөрчлийг арилгаж ажилласан байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

#### **5.1. Сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн талаар**

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн, 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Цагаанарал багийн ерөнхий сургууль, Цэцэгт багийн ерөнхий сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Сумын ЗДТГ, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Цагаанарал багийн ерөнхий сургууль, Цэцэгт багийн ерөнхий сургууль, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төвийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 133.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч үүнээс 4.6 сая төгрөгийн алдааг залруулж, 128.6 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн байна.

Бусад байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийтдээ 532.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч үүнээс 107.5 сая төгрөгийн алдааг залруулж, 7.6 сая төгрөгийн төлбөрийн 3 акт тогтоож, 403.5 сая төгрөгийн 6 албан шаардлага, 13.7 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн. Хүүхдийн цэцэрлэгийн 3 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөгдсөн.

*Хүснэгт №10. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангаас илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл хүснэгтээр харуулбал*

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Засаг даргын тамгын газар	3	127,856.20							3	127,856.20		
2	ИТХурал	5	5,355.60	4	4,640.60					1	715.00		
3	ОНХСан	0	-										
4	ХХСан	0	-										
<b>Орон нутгийн байгууллагын дүн</b>		<b>8</b>	<b>133,211.80</b>	<b>4</b>	<b>4,640.60</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>128,571.20</b>	<b>-</b>	<b>-</b>
1	Баяннуур сумын 1-р сургууль	3	22,928.50			1	3,447.50	1	8,114.00	1	11,367.00		
2	Баяннуур сумын Цагаанарал багийн бага сургууль	4	36,311.40	1	29,921.90	1	3,447.50	1	2,942.00	1	-		
3	Баяннуур сумын Цэцэгт багийн бага сургууль	3	12,162.50	1	7,749.50			1	4,413.00	1	-		
4	Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэг	4	3,269.00			1	756.00	1	2,513.00			2	3
5	Баяннуур сумын Эрүүл мэндийн төв	3	455,320.40	1	69,814.40			2	385,506.00				
6	Баяннуур сумын Соёлын төв	1	2,293.20							1	2,293.20		
<b>Байгууллагын дүн</b>		<b>18</b>	<b>532,285.00</b>	<b>3</b>	<b>107,485.80</b>	<b>3</b>	<b>7,651.00</b>	<b>6</b>	<b>403,488.00</b>	<b>4</b>	<b>13,660.20</b>	<b>2</b>	<b>3</b>
<b>Нийт дүн</b>		<b>26</b>	<b>665,496.80</b>	<b>7</b>	<b>112,126.40</b>	<b>3</b>	<b>7,651.00</b>	<b>6</b>	<b>403,488.00</b>	<b>8</b>	<b>142,231.40</b>	<b>2</b>	<b>3</b>

## 5.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 236.4 сая төгрөгийн алдааг залруулсан. *Залруулга:*

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Үйл ажиллагааны орлогын албан татварын орлогыг 236.4 сая төгрөгөөр дутуу, хөрөнгийн орлогын албан татварын орлогыг илүү тайлагнаж ирүүлснийг залруулав.

Аудитын дүнгээр Сумын Засаг дарга, Санхүүгийн албад дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

1. Сумын төсөвт байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчилд өгсөн 7.6 сая төгрөгийн төлбөрийн 3 актыг хугацаанд нь барагдуулах, 403.5 сая төгрөгийн 6 албан шаардлага, 142.2 сая төгрөгийн 8 зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллах;

*Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үйл ажиллагааны орлогын албан татварыг зөрүүтэй тайлагнасан	1	236,455.9			1	236,455.9	1	236,455.9				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>236,455.9</b>			<b>1</b>	<b>236,455.9</b>	<b>1</b>	<b>236,455.9</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ-ийн харьяа байгууллагуудад өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаагүй.	1						1					
<b>Дүн</b>	<b>1</b>						<b>1</b>					

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								